

**АЖ ҮЙЛДВЭРИЙН БАРАА ХУДАЛДААНЫ НЭГДЛИЙН
ТҮҮХЧИЛСЭН ЛАВЛАХ**

Нэг. Байгууллагын түүх

Хөдөлмөрчдийн худалдан авах эрэлт хэрэгцээ, үйлчилгээний эрэлт, шаардлагын дагуу хүнс, аж үйлдвэрийн барааны байгууллагыг тус тусад нь төрөлжүүлэх зорилгоор СнЗ-ийн 1986 оны 9 дүгээр сарын 16-ны өдрийн 294 дүгээр тогтоолыг хэрэгжүүлж, БНМАУ-ын Худалдаа бэлтгэлийн яам, УБ хотын АДХГ Захиргааны 1986 оны 296/196 дугаар тогтоолоор хотын худалдааны зохион байгуулалтад өөрчлөлт хийж “Хотын Худалдаа удирдах газар”-г төрөлжүүлэн “Хүнсний бараа худалдааны нэгдэл”, “Аж үйлдвэрийн бараа худалдааны нэгдэл” болгон салгаж өөрчилжээ.

Улаанбаатар хотын АДХ-ын Гүйцэтгэх захиргааны 1986 оны 09 дүгээр сарын 24-ны өдрийн дээрх тогтоолоор Улаанбаатар хотын Худалдаа удирдах газар, түүний харьяа бараа бааз, худалдааны 3,5,7 дугаар конторыг татан буулгаж АДХГЗ-ы харьяа Хүнсний бараа худалдааны нэгдэл, Аж үйлдвэрийн бараа худалдааны нэгдлийг 1986 оны 10 дугаар сарын 01-ээс байгуулах шийдвэр гарсан байна. Тус нэгдлийн анхны даргаар Д.Мижиддорж томилогдон 1986.10 сараас 1990.11 сар хүртэл ажиллав.

Улаанбаатар хотын Аж үйлдвэрийн барааны дэлгүүрүүдийн удирдлагыг төвлөрүүлэх үндсэн дээр УБ хотын АҮБХН-ийг нэгдсэн агуулах, дэлгүүрүүдийн нэгдсэн 16 захиргаа болон шууд харьяа дэлгүүрүүдтэй аж ахуйн тооцооны үндсэн дээр ажиллуулан түүний бүрэлдэхүүнд биеэ даасан аж ахуйн тооцоотой доорх байгууллагуудыг харьяалуулсан байна. Үүнд:

1. Улсын их дэлгүүр
2. Комиссын худалдааны дэлгүүр

Аж үйлдвэрийн бараа худалдааны нэгдлийн дэлгүүрүүдийн нэгдсэн жагсаалтыг дээрх тогтоолоор баталж өгсөн байна. Цаашид үйлчилгээний цэг салбар өргөжихийн хэрээр ЗХУ-ын туршлагаар нутаг дэвсгэрийн ойролцоо байдлаар нь болон барааны төрөлжилтөөр 2-5 дэлгүүр тус бүрт нэгдсэн захиргаа байгуулж байхаар тогтоожээ.

Аж үйлдвэрийн бараа худалдааны нэгдэл нь 16 нэгдсэн захиргаатай байх бөгөөд нийт 39 салбар дэлгүүртэй, 2 бие даасан томоохон нэгж дэлгүүртэйгээр үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн байна.

Аж үйлдвэрийн бараа худалдааны нэгдлийн харьяа дэлгүүрүүд, түүний захиргаад:

| Нэгдсэн захиргааны дугаар | Нэгдсэн захиргаа төвлөрөх дэлгүүр | Нэгдсэн захиргаанд харьяалагдах дэлгүүрүүд |
|---------------------------|-----------------------------------|--|
| 1 дүгээр Захиргаа | Аж үйлдвэрийн барааны дэлгүүр №16 | 48,50 |
| 2 дугаар захиргаа | Аж үйлдвэрийн барааны дэлгүүр №22 | 26 |
| 3 дугаар захиргаа | -* - №8 | 37,35 |
| 4 дүгээр захиргаа | -* - №27 | 1 |
| 5 дугаар захиргаа | -* - №32 | 34,40 |
| 6 дугаар захиргаа | -* - №2 | 54 |
| 7 дугаар захиргаа | -* - №12 | 49 |
| 8 дугаар захиргаа | -* - №19 | 31 |

| | | |
|--------------------|---------|-------|
| 9 дүгээр захиргаа | -*- №28 | 10,41 |
| 10 дугаар захиргаа | -*- №11 | 23 |
| 11 дүгээр захиргаа | -*- №24 | 6 |
| 12 дугаар захиргаа | -*- №36 | 4 |
| 13 дугаар захиргаа | -*- 46 | 47,3 |
| 14 дүгээр захиргаа | -*- №45 | 44,39 |
| 15 дугаар захиргаа | -*- №60 | 55,25 |
| 16 дугаар захиргаа | -*- №5 | 33 |

Шинээр байгуулагдсан нэгдэлд хотын худалдааны бааз, конторуудаас ажилчид шилжүүлэн ажиллуулж дараах 7 нэгж, салбар, 39 дэлгүүрийн нийт 1100-аад ажилтантай томоохон бүтэц, орон тоогоор үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн байна.

1. ҮНЭ ЧАНАРЫН ХЭЛТЭС: Хэлтсийн үйл ажиллагааны чиглэл нь үндсэн цэг салбар болон төв агуулахын өргөн хэрэгцээний барааны жижиглэн худалдаалах үнэ болон дэлгүүрт худалдагдаж байгаа барааны жижиглэн худалдаалах үнийн мөрдөлтөд хяналт тавих, эх орны үйлдвэрээс нийлүүлэгдэж байгаа бүтээгдэхүүний чанарыг шалгах, хөдөлмөрчдөд үнийн зөрчилгүй болон чанартай бараагаар үйлчлэхэд ажлаа чиглүүлдэг байна. Тус хэлтэс мэргэжилтэн, чанар шалгагч нараас бүрдсэн 14 орон тоотой.
2. ХУДАЛДААНЫ ХЭЛТЭС: мэргэжилтэн, эдийн засагч, хуулийн мэргэжилтэн, зааварлагч, тоо бүртгэгч, бичиг хэргийг эрхлэг, бичээч, төлөвлөгөөний эдийн засагч, хөдөлмөр цалин хөлсний эдийн засагч, төлөвлөгөөний техникч, статистицк нараас бүрдсэн 5 орон тоотой.
3. ХУДАЛДААНЫ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ТЕХНИКИЙН ХЭЛТЭС: Хэлтсийн үндсэн зорилт нь жижиглэн худалдаалах газруудын удирдлага зохион байгуулалтыг боловсронгуй болгох, төрөлжилт, өргөтгөл, засвар шинэчлэлт, байршлыг зөв тогтоох, оновчтой хөгжүүлэх, худалдаа үйлчилгээнд дэвшилтэт арга, нэмэлт үйлчилгээг өргөн нэвтрүүлэх, үйлчилгээний соёлыг дээшлүүлэх, бараа худалдаалах арга технологийг боловсронгуй болгох, худалдааны тавилга, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэлээр хангах үүрэгтэй. инженер-зохион байгуулагч, арга зүйн кабинетын эрхлэгч, арга зүйч, эрэлт судлах мэргэжилтэн, рекламн мэргэжилтэн, рекламчин гэсэн 6 орон тоотой.
4. БҮРТГЭЛ, ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ХЭЛТЭС: Тус хэлтэс нь байгуулагдахдаа дараах үндсэн зорилтыг хэрэгжүүлэхээр зохион байгуулагджээ. Тус нэгдлийн харьяа жижиглэн худалдаалах цэг салбаруудад социалист өмчийг нүдлэн хамгаалах арвижуулахад бүртгэлээр тавих хяналтыг сайжруулан, аж ахуйн үйл ажиллагаанд анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийг нэвтрүүлэх, тооллого тооцооны ажлыг чанартай явуулах, өр дутагдлыг шуурхай барагдуулах, санхүү төлбөр тооцооны журмыг хатуу сахиулж, эдийн засгийн үр дүнг сар, улирал, жилээр үнэн зөв тайлагнах, аж ахуйн үйл ажиллагаанд баримтын шалгалт хийх бүртгэл хяналтын албыг мэргэжлийн удирдлагаар хангах үүрэгтэй байна. Хэлтсийн бүтэц орон тооны хувьд орлогч дарга, ахлах нябо, бүртгэлийн арга зүйч, байцаагч нябо, цалин хөлсний нябо, аж ахуйн нябо, зээл-тооцооны нябо, группийн ахлагч, тооцооны нябо, баримт шалгагч нябо, хяналтын групп, туслах, тооцооны нябо зэрэг 84 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулдаг нэлээн нүсэр бүтэцтэй байсан байна.

5. Төв агуулахад: төв агуулахын эрхлэгч, хамгаалалтын мэргэжилтэн, бараа шалган тоологч, агент нярав, эрхлэгч нярав, туслах нярав, туслах ажилтан, харуул, манаач, ачигч, аж ахуйн нярав, материалын нярав, жолооч, монтёр, мужаан, үйлчлэгч, касс, слесарь, мөнгөний нярав, диспетчр, наряд бичигч, бараа хуваарилагч зэрэг 146 орон тоотой
6. Мэргэжилтэн: 23 орон тоотой
7. Дэлгүүрүүд: нийт 39 дэлгүүрийн 916 ажилтан албан хаагчидтай байжээ.

Аж үйлдвэрийн бараа худалдааны нэгдэл нь Худалдаа бэлтгэлийн яамны сайдын 1986 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн 309 дүгээр тушаалыг үндэслэн Нэгдлийн даргын 10 дугаар сарын 23-ны өдрийн 06 дугаар тушаалаар өөрийн байгууллагын дэргэд Барилга засварын байнгын бригадыг ажиллуулж эхэлсэн байна. Тус бригад нь бригадын дарга 1, засварын нормчин 7 хүний бүрэлдэхүүнтэй ажиллах бөгөөд нэгдлийн харьяан дахь барилга байгууламж, дэлгүүрүүдийн барилгын засвар үйлчилгээг цаг алдалгүй хийх үүрэгтэй байв.

Улсын их дэлгүүр болон, Комиссын барааны дэлгүүрийн дарга нарыг АҮБХН-ийн дарга томилж, хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллуулдаг байна.

АҮБХН нь үйл ажиллагаагаа өргөжүүлэн, ажилтан албан хаагч, боловсон хүчнээ нэмэгдүүлж ажиллах хүчний хувьд бэхжиж байсан нь 1986 оны сүүлийн байдлаар нийт ажилтан албан хаагчдын тоо 2094-д хүрч үүнээс эмэгтэй ажилчид 1653 байв.

БНМАУ-ын ХБЯ, Сангийн яамны сайдын 1987 оны 359/322 дугаар тушаалын заалтыг биелүүлэх зорилгоор тус нэгдлээс нэгэн шинэ ажил зохион байгуулсан нь хөдөлмөрчдөд барааг зээлээр худалдаалах үйлчилгээг анх нэвтрүүлсэн явдал байв. Тухайн үед УИД, 3, 8, 24, 29, 48 дугаар дэлгүүрүүдэд барааг зээлээр худалдаж байсан бөгөөд эдгээр барааны нэр төрөл нь мотоцикль, моторт дугуй, унадаг дугуй, угаагч машин, цахилгаан зуух, гэрийн хөргөгч, ханын тавилга, гал тогооны тавилга, хувцасны шкаф, телевизор, пянз тоглуулагч, магнитофон, транзистор, пиано, баянхуур хөгжим, гэрэл зургийн аппарат, дуран, хивс, морин тэрэг гэх мэт бараануудыг зээлээр худалдаалж байжээ.

АҮБХН-ийн даргын 1988 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 24 дүгээр тушаалаар төрөлжсөн дэлгүүр байгуулах шийдвэр гаргажээ. Энэхүү дэлгүүр нь радио хүлээн авагч, зурагт радио, гэрэл зургийн аппарат, төрөл бүрийн цаг зэрэг нарийн механизмын барааг төрөлжүүлэн худалдаж, эдгээр бараануудад баталгаат засварын үйлчилгээ хийх, мөн барааны эрэлт хүсэлтийг судалж, хэрэгцээг тодорхойлох, худалдаа үйлчилгээний нэгэн цогц салбар бий болгох зорилгоор аж үйдвэрийн барааны 50 дугаар дэлгүүрийг төрөлжүүлэн зохион байгуулсан байна.

1988 онд аж үйлдвэрийн барааны дэлгүүрүүдийг шинэ зохион байгуулалтад оруулсан байна. БНМАУ-ын ХБЯ, УБ хотын АДХГЗ-ы 1988 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн 34 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэхээр АҮБХН-ийн даргын шийдвэрээр шинээр райончлон зохион байгуулагдсан дэлгүүрүүдийн нэгдсэн захиргааг шинээр байгуулж, захиргааны дарга нарыг томилсон байна.

Район тус бүрд байрлах дэлгүүрүүдийг 1, 2 дугаар группт хуваан нэгдсэн захиргаадыг байгуулсан. Үүнд: Сүхбаатарын районы 1 дүгээр группийн харьяалалд байгаа дэлгүүрүүдийн нэгдсэн захиргааны даргаар Жанлавын Дариймаа, 2 дугаар группийн дарга

Жагдалын Доржсүрэнг, Октябрийн районы 2 дугаар группийн нэгдсэн захиргааны даргаар Уужингийн Буджав, Ажилчны районы нэгдсэн захиргааны даргаар Гунгаагын Нансал, Найрамдлын районы нэгдсэн захиргааны даргаар Төмөр-Очирын Нэргүйг тус тус томилжээ.

Тус нэгдэл нь туслах аж ахуйтай байсан бөгөөд нэгдлийн ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдэх, төмс, хүнсний ногоо, мах сүүгээр хангах ажлыг тасралтгүй явуулж, гахайн аж ахуй эрхлэх, туслах аж ахуйн хэрэгцээт үнээ, бяруу зэрэг малыг амины малтай иргэдээс худалдан авах ажлыг зохион байгуулж байжээ.

БНМАУ-ын СнЗ-ийн 1988 оны 01 дүгээр сарын 29-ны өдрийн 14 дүгээр тогтоолыг хэрэгжүүлж Төмөр замын худалдааны IV контор татан буугдаж тус конторын харьяанд байсан аж үйлдвэрийн барааны 6, 17, 18 дугаар дэлгүүрүүдийг ажилчдын хамт нэгдлийн мэдэлд шилжүүлсэн байна.

УБ хотын АДХГЗ-ны 1990 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн Б/193 дугаар захирамжаар Гэлэгийн Энхтайваныг АҮБХН-ийн даргаар томилж, Мижиддоржийг чөлөөлсөн байна.

Нэгдлийн зохион байгуулалтад өөрчлөлт орж нэгдлийн даргын 1991 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 19 дүгээр тушаалаар нэгдлийн захиргаанд багтан ажиллаж байсан төв агуулахыг мөн оны 03 дугаар сарын 01-ээс эхлэн бие даалган аж ахуйн бүрэн тооцоонд шилжүүлэн ажиллуулахаар болж АҮБХН-ийн харьяа Төв агуулах гэх болжээ. Даргаар Ч.Банзай томилогдон ажиллаж байв.

Тус Төв агуулах нь нэгдлээс өргөн хэрэглээний бараа бэлтгэн нийлүүлэгч, үйлдвэр, аж ахуйн газрууд, пүүс хоршоолол, бараа үйлдвэрлэгчдээс авахаар лимит хуваарь өгөгдсөн барааг аж ахуйн гэрээ байгуулан татан авч, тоо чанарын шалгалт хийж, задлан найруулан нэгдлийн харьяа жижиглэн худалдаалах байгууллага, цэг салбаруудад нэгдлээс өгсөн хуваарийг үндэслэн хуваарилан хүргэх, хангамж, барааны нэр төрөл, бүрдэлтийн ажлыг хариуцсан аж ахуйн тооцоотой байгууллага юм.

Зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжих шилжилтийн үед олон байгууллагууд хувьчлагдах, татан буугдах, үйл ажиллагаагаа зогсоох зэрэг хүнд нөхцөлд тулж ирсэн үед АҮБХН-ийн харьяа дэлгүүрүүдийг зах зээлийн харилцааны жамаар тухайн хамт олны хүсэлтийн дагуу түрээслэн өгч, өмч хувьчлалын анхны хэлбэрт шилжүүлэн бие даалгах зорилгоор АҮБХН-ийн даргын 1991 оны 03 дугаар сарын 31-ны өдрийн 46 дугаар тушаалаар зарим дэлгүүрүүдийн түрээсийн хэлбэрт шилжүүлэн ажиллуулсан байна.

Дээрх онд ихэнхи дэлгүүрүүд түрээсийн хэлбэрт шилжин ажиллах болсонтой холбогдуулан аж ахуйн тооцоотой дэлгүүрийн нэгдсэн захиргаадыг татан буулгажээ.

Тухайн үед түрээсээр ажиллаагүй байсан 48, 50 дугаар дэлгүүрийг Хүүхдийн барааны их дэлгүүрт харьяалуулан ажиллуулахаар болжээ.

Нэгдлийн харьяанд ажиллаж байсан Комиссын худалдааны дэлгүүр нь 1991 оны 04 дүгээр сарын 01-ээс эхлэн “Дэлгэрэх” пүүс болон зохион байгуулагджээ.

Улаанбаатар хотын АДХГЗ-ны шийдвэрийн дагуу зэвсэгт хүчний 0230 дугаар ангиас 4 айлын сууцны барилгыг хүлээн авч тус нэгдлийн харьяаны аж үйлдвэрийн барааны 52 дугаар дэлгүүрийг шинээр байгуулан ажиллуулсан байна.

Зах зээлийн харилцаанд шилжин томоохон үйлдвэр, худалдааны байгууллагууд аж ахуйн тооцоон дээр ажиллаж, нэгдэн зохион байгуулагдаж, хувьчлагдаж, татан буугдаж байсан энэ үед АҮБХН нь өөрийн харьяаны салбар дэлгүүр, цэг салбаруудаа түрээсийн журмаар ажиллуулах, хувьчлах зэргээр худалдааны салбарт нэлээн өөрчлөлт хөдөлгөөн хийгдсэн байна.

Төрийн зохицуулалттай зах зээлийн эдийн засагт шилжиж байгаатай хоблогдуулан нийслэл хотын хэмжээнд худалдаа хоолны нэгдсэн бодлого явуулах, мэргэжлийн удирдлагаар хангах зорилгоор УБ хотын АДХГЗ-ы 1991 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн 226 дугаар тогтоолоор Хотын хүнсний бараа худалдааны нэгдэл, аж үйлдвэрийн бараа худалдааны нэгдэл, нийтийн хоолны үйлдвэрлэлийн нэгдэл тэдгээрийн харьяа газруудыг татан буулгаж, хөдөлмөрчдийн нийтлэг эрх ашигт нийцүүлэн, салбарын нэгдсэн бодлого боловсруулан хотын хэмжээнд хэрэгжүүлэх, улс хоршоолол, хувийн худалдаа, нийтийн хоолны байгууллагуудын үйл ажиллагаа тэдгээрийн бараа хангамж, хуваарилалт, үйлчилгээг зохицуулж мэргэжлийн удирдлагаар хангах, хяналт тавих зорилгоор ХБХН, АБХН, нийтийн хоолны трестүүдийг нэгтгэн өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллах Улаанбаатар хотын Худалдаа хоолны ерөнхий компанийг байгуулсан байна.

Зах зээлийн нөхцөл дэх хүн амын хүнсний болон өргөн хэрэглээний барааны хагнамжийг сайжруулахад чиглэсэн экспорт, импортын үйл ажиллагаа явуулах, өргөн хэрэглэний барааны бирж ажиллуулах, зорилгоор ХХЕК-ы бүтэц үйл ажиллагаа чиг үүргийг өөрчилж, Улаанбаатар хотын Засаг даргын 1992 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн А/83 дугаар захирамжаар Хотын худалдаа хоолны ерөнхий компанийг одоогийн материалаг баазад тулгуурлан “Нийслэлийн худалдаа, нийтийн хоолны Улаанбаатар-импекс” компани /УҮГ/ болгон өргөн хэрэглээний барааны бирж, валютын дэлгүүртэйгээр байгуулсан байна.

“Улаанбаатар- импекс” компаний ерөнхий захирлаар Ж.Октябрийг томилжээ.

Аж үйлдвэрийн бараа худалдааны нэгдлийг удирдаж байсан дарга нар

- Дарга Д.Мижиддорж- 1986.10 сар-1990.11 сар
- Дарга Г.Энхтайван - 1990.11 сар- 1992 он

Нэг. Хөмрөгийн баримтын түүх

Аж үйлдвэрийн бараа худалдааны нэгдлийн бичиг хэргийн эрхлэгчээр З.Батжаргал, түүний дараа Ш.Бадамханд архив, бичиг хэргийн эрхлэгчээр тус тус томилогдон ажиллаж байв.

Нэгдлийн даргын 1989 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн 66 дугаар тушаалаар архив бичиг хэргийн улсын үзлэгт бэлтгэх комиссыг 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулжээ. Комиссын гишүүдэд Л.Бадмаараг /хэлтсийн дарга/, Г.Сэмбэн /байцаагч, нябо/,

З.Батжаргал /бичиг хэргийн эрхлэгч/, Т.Даваа /нябо/, З.Бэгзсүрэн /зааварлагч/ нар томилогдон ажилласан байна.

Мөн оны 10 дугаар сарын 18-ны өдрийн 286 дугаар тушаалаар нэгдлийн үйл ажиллагааны явцад бий болсон баримт бичиг, архивын баримтыг нягтлан шалгах комисс байгуулж ажиллуулан нэгдлийн хэлтэс тасгуудын үйл ажиллагааны явцад бий болсон баримтыг албан хэрэг хөтлөлтийн зааврын дагуу зөв бүрдүүлэн данс бүртгэлтэй болгож харьяа газруудын архивын баримтыг нэгтгэн баяжуулах зэрэг ажлыг хийж гүйцэтгэхээр болсон байна.

АҮБХН-ийн архивын баримт бичиг “Улаанбаатар импекс” компанид шилжин очсон бөгөөд, 1995 онд “Улаанбаатар импекс” компаниас АҮБХН-ийн үйл ажиллагаанд холбогдох 1986-1991 оны 40 хадгаламжийн нэгж баримтыг нийслэлийн архивын газарт шилжүүлэн өгсөн байна.

Хөмрөгийн баримтын тодорхойлолт: АҮБХН-ийн даргын 1986-1991 оны тушаал, хурлын тэмдэглэл, үйлдвэр санхүүгийн төлөвлөгөө, ажиллах хүчний тайлан, мөн Төв агуулахын 1991 оны даргын тушаал, хурлын тэмдэглэл зэрэг бүрдэлтэй нийт 40 хадгаламжийн нэгж баримттай байна. 1991 оны Төв агуулахын даргын тушаал, хурлын тэмдэглэл бий.

2012 онд тус хөмрөгийн захирамжлалын 13 хадгаламжийн нэгж, 2959 хуудас баримтад оператор Б.Мянхай цахим хувь үйлдэж цахим баримттай болсон байна.

Төрийн архивын үндсэн заавар, журмын дагуу хөмрөгийн баримтад нэгдсэн тооллого хийх ажлыг 2004 онд Ц.Рэгзэдмаа, 2006 онд Л.Долгор, 2008 онд Хандаа, 2010 онд Д.Анхбаяр, 2012 онд У.Даваажав /70 жил/, 2013 онд /70 жил/, Ё.Оюунцэцэг, байнга хадгалах баримтад Ц.Даваадонид нар тус тус тооллого хийсэн байна.

2012 онд нийслэлийн Архивын газраас зохион байгуулсан түүхчилсэн лавлах бичих уралдаанд оюутан Ерөөлтням тус хөмрөгийн баримтыг судлан үзэж түүхчилсэн лавлахыг бичиж байжээ.